



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын албан ажлын хэрэгцээнд зориулан нийт 81,000,000.00 (наян нэгэн сая) төгрөгөөр 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 1 ширхэг автомашин олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХҮҮЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000839

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн  
416 дугаар тогтоолын хавсралт



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий  
газрын олж авах автомашин

| Д/д | Хөрөнгийн нэр                                                            | Нэг бүрийн<br>үнэ (төгрөг) | Тоо<br>ширхэг | Худалдан авах үнийн дээд<br>хязгаар (төгрөг) |
|-----|--------------------------------------------------------------------------|----------------------------|---------------|----------------------------------------------|
| 1   | Суудлын,<br>хөдөлгүүрийн<br>багтаамж 3500 cc<br>хүртэл,<br>суудлын тоо 5 | 81,000,000.00              | 1             | 81,000,000.00                                |
|     | Нийт дүн                                                                 |                            | 1             | 81,000,000.00<br>(наян нэгэн сая)            |